УВС ФИНАНС АУДИТ ХХК

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/119/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК
аудитор: Я.Тунгалаг
Утас: 99458717 Цахим хаяг:ynarantuya310@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 № УВА-2023/119/НА-СТАТИЗ

танай ________ -ны № ________ -т

БӨХМӨРӨН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ П. ГАНСҮХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол шинжлэх ухааны яамнаас үнэ төлбөргүй 3,404.3 мянган төгрөгийн ном, хандиваар 255.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 52,583.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 18,305.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

0200000423

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3

**Дүгнэлтийн үндэслэл** ..... 4

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно... 4

**Асуудлыг онцолсон хэсэг** ..... 4

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 6

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 13

**4.1 Ерөнхий зүйл** ..... 17

**4.2 Материаллаг байдал** ..... 17

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 17

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 17

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 17

**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 18

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 18

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 18

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **90,695,442.68** | **119,731,729.20** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 12,266,564.52 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 12,266,564.52 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 12,266,564.52 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 12,266,564.52 |
| **33** | **АВЛАГА** | 16,472,951.80 | 20,423,591.80 |
| **335** | **Бусад авлага** | 16,472,951.80 | 20,423,591.80 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 3,950,640.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 16,472,951.80 | 16,472,951.80 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 74,222,490.88 | 87,041,572.88 |
| **351** | **Түүхий эд материал** | 00.00 | 187,500.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 187,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 74,222,490.88 | 86,854,072.88 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 16,192,439.32 | 14,810,889.32 |
| 35420 | Аж ахуйн материал | 55,270,651.56 | 60,458,553.56 |
| 35460 | Хүнсний материал | 2,759,400.00 | 11,584,630.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,508,236,073.31** | **2,480,990,177.84** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,508,236,073.31 | 2,480,990,177.84 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,446,638,073.31 | 2,419,392,177.84 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,431,950,955.00 | 2,431,950,955.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -156,104,176.30 | -216,646,892.14 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 32,500,000.00 | 32,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -14,895,833.37 | -20,312,500.05 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 243,371,215.00 | 290,597,230.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -187,899,794.43 | -188,543,606.91 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 183,133,860.15 | 188,010,309.65 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -110,387,539.81 | -126,537,035.74 |
| 39217 | Ном | 24,969,387.07 | 28,373,718.03 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 61,598,000.00 | 61,598,000.00 |
| 39301 | Програм хангамж | 440,000.00 | 440,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -440,000.00 | -440,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 61,598,000.00 | 61,598,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,598,931,515.99** | **2,600,721,907.04** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **11,747,017.00** | **1,020,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 11,747,017.00 | 1,020,000.00 |
| **413** | **Өглөг** | 11,747,017.00 | 1,020,000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 9,775,000.00 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,972,017.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 1,020,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 1,020,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,587,184,498.99** | **2,599,701,907.04** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,587,184,498.99 | 2,599,701,907.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 820,075,316.80 | 820,075,316.80 |
| 51101 | Өмч: - төрийн | 820,075,316.80 | 820,075,316.80 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,423,247,921.64 | 1,435,967,677.69 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,423,247,921.64 | 1,423,450,269.64 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 12,517,408.05 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 343,861,260.55 | 343,658,912.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,598,931,515.99** | **2,600,721,907.04** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **914,638,963.92** | **1,277,003,630.96** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **743,445,192.92** | **67,168,630.96** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 18,182,792.92 | 67,168,630.96 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 18,182,792.92 | 1,859,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,859,300.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 18,182,792.92 | 00.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 725,262,400.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 725,262,400.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **171,193,771.00** | **1,209,835,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 990,533,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 990,533,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,968,971.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,300,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 668,971.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 166,224,800.00 | 219,301,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 166,224,800.00 | 219,301,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **999,393,213.98** | **1,264,337,368.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **999,393,213.98** | **1,264,337,368.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 973,046,816.45 | 1,191,764,243.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 577,288,709.00 | 711,606,471.00 |
| 210101 | Үндсэн цалин | 388,678,905.00 | 493,059,159.00 |
| 210102 | Нэмэгдэл | 141,458,135.00 | 169,844,231.00 |
| 210104 | Урамшуулал | 37,071,669.00 | 45,343,081.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 10,080,000.00 | 3,360,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 75,164,398.47 | 88,087,283.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,483,097.13 | 60,634,229.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,782,967.09 | 7,133,438.96 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,630,909.69 | 5,706,749.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,066,236.02 | 1,328,442.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,201,188.54 | 13,284,422.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 165,696,817.00 | 169,096,098.53 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,998,968.00 | 11,398,249.53 |
| 210302 | Түлш, халаалт | 157,697,849.00 | 157,697,849.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,869,800.00 | 22,386,798.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 536,000.00 | 4,543,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,219,300.00 | 7,361,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 334,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,433,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,292,500.00 | 5,336,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 55,000.00 | 5,145,998.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 41,115,470.00 | 73,383,445.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 407,300.00 | 49,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 40,708,170.00 | 73,334,345.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,295,500.00 | 3,803,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,295,500.00 | 3,803,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 574,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 574,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,239,325.00 | 1,020,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,000.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 95,625.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 37,500.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 1,020,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 101,802,796.98 | 122,381,147.26 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 14,528,225.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,954,600.00 | 6,208,550.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 98,848,196.98 | 101,644,372.26 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26,346,397.53 | 72,573,125.23 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 25,514,000.00 | 65,316,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,496,500.00 | 47,944,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,017,500.00 | 17,371,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 832,397.53 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 7,256,825.23 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,256,825.23 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-84,754,250.06** | **12,666,262.22** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 148,854.17 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 148,854.17 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -148,854.17 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | -84,754,250.06 | 12,517,408.05 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **896,456,171.00** | **1,211,694,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **725,262,400.00** | **1,859,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 1,859,300.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 1,859,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,859,300.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 725,262,400.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **171,193,771.00** | **1,209,835,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 990,533,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 990,533,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,968,971.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,300,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 668,971.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 166,224,800.00 | 219,301,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 166,224,800.00 | 219,301,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **896,456,171.00** | **1,181,122,735.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **896,456,171.00** | **1,181,122,735.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **870,109,773.47** | **1,108,549,610.25** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 565,878,800.00 | 721,381,471.00 |
| 210101 | Үндсэн цалин | 377,268,996.00 | 502,834,159.00 |
| 210102 | Нэмэгдэл | 141,458,135.00 | 169,844,231.00 |
| 210104 | Урамшуулал | 37,071,669.00 | 45,343,081.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 10,080,000.00 | 3,360,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 76,799,307.47 | 88,087,283.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 55,118,006.13 | 60,634,229.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,782,967.09 | 7,133,438.96 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,630,909.69 | 5,706,749.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,066,236.02 | 1,328,442.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,201,188.54 | 13,284,422.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 163,724,800.00 | 172,068,115.53 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,998,968.00 | 11,398,249.53 |
| 210302 | Түлш, халаалт | 155,725,832.00 | 160,669,866.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,826,571.00 | 00.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 531,971.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,219,300.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 334,000.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,658,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,077,300.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,418,870.00 | 82,159,575.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 407,300.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 43,467,570.00 | 82,159,575.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 544,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,750,000.00 | 2,500,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,250,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 574,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 574,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,339,325.00 | 5,410,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,000.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 95,625.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 37,500.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 700,000.00 | 5,410,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,798,100.00 | 36,942,765.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 26,930,315.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,798,100.00 | 10,012,450.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **26,346,397.53** | **72,573,125.23** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 25,514,000.00 | 65,316,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,496,500.00 | 47,944,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,017,500.00 | 17,371,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 832,397.53 | 00.00 |
| 213304 | Хөрөнгийн | | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 7,256,825.23 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,256,825.23 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **30,571,564.52** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **18,305,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **18,305,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 18,305,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 18,305,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-18,305,000.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 12,266,564.52 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **12,266,564.52** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 758,477,316.80 | 626,728,956.32 | 295,883,490.50 | 1,681,089,763.62 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 30,048.00 | 30,048.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **758,477,316.80** | **626,728,956.32** | **295,913,538.50** | 1,681,119,811.62 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | -30,048.00 | 00.00 | -30,048.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -8,144,635.82 | -8,144,635.82 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **820,075,316.80** | **343,861,260.55** | **1,423,247,921.64** | 2,587,184,498.99 |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **820,075,316.80** | **343,861,260.55** | **1,423,247,921.64** | 2,587,184,498.99 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 202,348.00 | 202,348.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **820,075,316.80** | **343,861,260.55** | **1,423,450,269.64** | 2,587,386,846.99 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -202,348.00 | 00.00 | -202,348.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 12,517,408.05 | 12,517,408.05 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **820,075,316.80** | **343,658,912.55** | **1,435,967,677.69** | 2,599,701,907.04 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/**

**/төгрөг/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Гүйцэтгэл зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| !! | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **992,395,200.00** | **980,125,835.48** | **12,269,364.52** | 98.8 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **992,395,200.00** | **980,125,835.48** | **12,269,364.52** | 98.8 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **926,862,900.00** | **914,809,535.48** | **12,053,364.52** | 98.7 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **690,513,100.00** | **687,978,174.00** | **2,534,926.00** | 99.6 |
| 210101 | Үндсэн цалин | 523,787,300.00 | 477,604,914.00 | **46,182,386.00** | 91.2 |
| 210102 | Нэмэгдэл | 148,128,000.00 | 167,188,498.00 | **-19,060,498.00** | 112.9 |
| 210104 | Урамшуулал | 18,597,800.00 | 43,184,762.00 | **-24,586,962.00** | 232.2 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 0.00 | **0.00** | 0.0 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **86,314,200.00** | **84,013,621.48** | **2,300,578.52** | 97.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,693,600.00 | 57,864,139.55 | **829,460.45** | 98.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,905,100.00 | 6,807,545.99 | **97,554.01** | 98.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,524,100.00 | 5,446,035.47 | **78,064.53** | 98.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,381,000.00 | 1,263,263.59 | **117,736.41** | 91.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,810,400.00 | 12,632,636.88 | **1,177,763.12** | 91.5 |
| **2105** | **Нормативт зардал** | **85,344,300.00** | **82,159,575.00** | **3,184,725.00** | 96.3 |
| 210502 | Хоол, хүнс | 85,344,300.00 | 82,159,575.00 | **3,184,725.00** | 96.3 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,543,600.00** | **5,410,400.00** | **3,133,200.00** | 63.3 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,681,500.00 | 5,410,400.00 | **1,271,100.00** | 81.0 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **56,147,700.00** | **55,247,765.00** | **899,935.00** | 98.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,125,500.00 | 45,235,315.00 | **890,185.00** | 98.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,022,200.00 | 10,012,450.00 | **9,750.00** | 99.9 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **65,532,300.00** | **65,316,300.00** | **216,000.00** | 99.7 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **65,532,300.00** | **65,316,300.00** | **216,000.00** | 99.7 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 48,160,500.00 | 47,944,500.00 | **216,000.00** | 99.6 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,371,800.00 | 17,371,800.00 | **0.00** | 100.0 |
| III | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **992,395,200.00** | **992,392,400.00** | **2,800.00** | 100.0 |
| 31 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **990,533,100.00** | **990,533,100.00** | **0.00** | 100.0 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 990,533,100.00 | 990,533,100.00 | **0.00** | 100.0 |
| 35 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,862,100.00** | **1,859,300.00** | **0.00** | 99.8 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,862,100.00 | 1,859,300.00 | 0.00 | 99.8 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.0 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 12,266,564.52 | 12,266,564.52 | 0.0 |
| 62 | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 49 | 48 | **0.00** | 98.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 35 | 34 | 0.00 | 97.1 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11 | 11 | 0.00 | 100.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 2 | 2 | 0.00 | 100.0 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/**

**/төгрөг/**

| ЭА | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **219,301,900.00** | **212,045,074.77** | 7,256,825.23 | 96.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **219,301,900.00** | **212,045,074.77** | 7,256,825.23 | 96.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **219,301,900.00** | **212,045,074.77** | 7,256,825.23 | 96.7 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 33,403,300.00 | 33,403,297.00 | 3.00 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 30,043,300.00 | 25,229,245.00 | 4,814,055.00 | 84.0 |
| 210102 | Нэмэгдэл | | 2,655,733.00 | -2,655,733.00 | 0.0 |
| 210104 | Урамшуулал | | 2,158,319.00 | -2,158,319.00 | 0.0 |
| 210105 | ээт ажлын хөлс | 3,360,000.00 | 3,360,000.00 | 0.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **4,073,800.00** | **4,073,662.24** | 137.76 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,770,100.00 | 2,770,090.36 | 9.64 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 325,900.00 | 325,892.97 | 7.03 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 260,700.00 | 260,714.35 | -14.35 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 65,200.00 | 65,178.62 | 21.38 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 651,900.00 | 651,785.94 | 114.06 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **179,324,800.00** | **172,068,115.53** | 7,256,684.47 | 96.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,775,000.00 | 11,398,249.53 | -3,623,249.53 | 146.6 |
| 210302 | Түлш, халаалт | 171,249,800.00 | 160,669,866.00 | 10,579,934.00 | 93.8 |
| 210304 | Цэвэр ус | 300,000.00 | | 300,000.00 | 0.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,500,000.00** | **2,500,000.00** | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **219,301,900.00** | **212,045,074.77** | 7,256,825.23 | 96.7 |
| **1310** | **ОРОН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **219,301,900.00** | **212,045,074.77** | 7,256,825.23 | 96.7 |
| 131001 | Орон төсвөөс санхүүжих | 219,301,900.00 | 212,045,074.77 | 7,256,825.23 | 96.7 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 49.00 | 48.00 | 1.00 | 98.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 35.00 | 34.00 | 1.00 | 97.1 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11.00 | 11.00 | 0.00 | 100.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 02.00 | 02.00 | 0.00 | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих хүүхэд бүрийн сурч хөгжих сургалтын таатай орчин бүрдүүлэн сургалтын чанар үр дүнд ахиц гаргах зорилго тавин ажиллаж байна. Ардын өв уламжлал, ёс заншил, зорилтод хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн тоглоом наадгайгаар дамжуулан бүтээлч үйлийн орчин бүрдүүлэн ард иргэдийн итгэл хүлээсэн инээж угтаж, сургуулийн өмнөх боловсролын сурагчдад эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаарын сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,790.4 мянган төгрөгөөр буюу 0.06 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 12,266.6 | 12,266.6 |
| Авлага | 16,472.9 | 20,423.6 | 3,950.6 |
| Бараа материал | 74,222.5 | 87,041.6 | 12,819.1 |
| Үндсэн хөрөнгө | 2,508,236.1 | 2,480,990.2 | -27,245.9 |
| **Нийт хөрөнгө** | **2,598,931.5** | **2,600,721.9** | **1,790.4** |
| Өр төлбөр | 0.00 | 1,020.0 | 1,020.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,587,184.5 | 2,599,701.9 | 12,517.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,598,931.5** | **2,600,721.9** | **1,790.4** |

Тайлант оны эхэнд тэг төгрөг эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 12,266.6 мянган төгрөг болж өссөн нь улсын төсвийн дансны үлдэгдэл төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 20,423.6 мянган төгрөг болж 3,950.6 мянган төгрөг өссөн нь түлш халаалт болон бусад тооцооны авлага нэмэгдсэн шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 87,041.6 мянган төгрөг болж 12,819.1 мянган төгрөгөөр аж ахуйн материалын үлдэгдэл өссөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,480,990.2 мянган төгрөг болж буурсан байна. Энэ нь Боловсрол шинжлэх ухааны яамнаас үнэ төлбөргүй 3,404.3 мянган төгрөгийн ном, хандиваар 255.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 52,583.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 18,305.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 19,040.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсан утгасан, тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 1,020.0 мянган төгрөгөөр өссөн нь байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,599,701.9 мянган төгрөг болж 12,517.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 830,716.5 мянга, орон нутгийн төсвөөс 219,301.9 мянга, нийт зарлагыг 1,050,018.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 161,675.9 мянган төгрөгөөр өсөж, 1,211,694.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс, НДШ, нормативт зардалд **төлөвлөсөн зардал нэмэгдсэнтэй холбоотой.**

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 990,533.1 мянга, орон нутгийн төсвөөс 219,301.9 мянга, үйл ажиллагааны орлогоос 1,859.1 мянга, нийт 1,211,694.3 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 990,533.1 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 219,301.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, түрээсийн номын орлого 1,859.3 мянган төгрөг нийт 1,211,694.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,192,170.8 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 7,256.8 мянган төгрөг төвлөрүүлж, улсын төсвийн дансанд 12,266.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Улсын төсвийн үндсэн үйл ажиллагааны зардал | 992,395.2 | 980,125.8 | 12,269.4 | 98.7 |
| 2 | Орон нутгийн үндсэн үйл ажиллагааны зардал | 219,301.9 | 212.045.1 | 7,256.8 | 96.6% |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,192,170.8 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 2,534.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2,300.5 мянга, хүүхдийн хоолны зардлыг 3,184.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 899.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 3,133.2 мянга, төрөөс иргэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 216.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлага гараагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Увс Финанс Аудит" ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс финанс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 999.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,264.3 сая төгрөгийн 1 хувь буюу 12.6 сая төгрөгөөс 80 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 147 хугацаа хоцроож 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургууль нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 392.9 | 1 | 392.9 | 100% |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **392.9** | **1** | **392.9** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | Буруу тусган илэрхийлсэн | Үнэлэс | | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулсан | Залруулаагүй | |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:
УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР /Я.ТУНГАЛАГ/

2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр